

**ТЕЛЕВИЗУУДИЙН НЭВТРҮҮЛЖ БУЙ ДОХИОНЫ
ХЭЛНИЙ ХЭЛМЭРЧ, ХАДМАЛ ТАЙЛБАРТАЙ
НЭВТРҮҮЛГИЙН ХҮРТЭЭМЖ,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ҮР ДҮН**

2024

**ӨРГӨН
НЭВТРҮҮЛГИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР**

ТЕЛЕВИЗҮҮДИЙН НЭВТРҮҮЛЖ БУЙ ДОХИОНЫ ХЭЛНИЙ ХЭЛМЭРЧ, ХАДМАЛ ТАЙЛБАРТАЙ НЭВТРҮҮЛГИЙН ХҮРТЭЭМЖ, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР ДҮН

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх хэсэгт “... телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх” гэж заасан байдаг.

Тус Хорооноос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.4-т заасан хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлгийн хувь хэмжээг тодорхойлох чиг үүргийн дагуу Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан гаргах үүргийг “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”¹-аар хүлээлгэдэг. Энэ нь дохионы хэлний хэлмэрчийн хүрэлцээ хязгаарлагдмал байдлыг харгалзан шат дараатай авч буй арга хэмжээний нэг бөгөөд дохионы хэлтэй нэвтрүүлэх нэвтрүүлгийн хувь хэмжээг шууд заах боломжгүй байгаа юм. Телевиз нь жил бүр өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан ямар нэвтрүүлгээ дохионы хэлтэй нэвтрүүлэх, ямар нэвтрүүлгээ хадмал тайлбартай нэвтрүүлэхээ маягтын дагуу гарган тус Хороонд ирүүлж байгаа бөгөөд жил тутам үе шаттайгаар нэмэгдүүлэх байдлаар төлөвлөж ирүүлэх шаардлагыг тавьж ажиллаж байна. Телевизүүдийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийн хэрэгжилтийн байдлыг сар, улирал, жил тутам тайлагнан ажиллаж байна.

Энэхүү судалгааны товч тайлангаар дараах мэдээллийг нэгтгэн гаргахыг зорилоо. Үүнд:

- Телевизүүдийн дээрх хууль тогтоомжоор хүлээсэн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүргээ хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаарх нэгдсэн мэдээлэл (Телевизүүдийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн 2023 оны хэрэгжилтийн тайланд үндэслэн гаргав);
- Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизүүдэд хууль тогтоомжоор хүлээлгэж байгаа дээрх шаардлага нь сонсголын бэрхшээлтэй иргэдэд ойлгомжтой хүрч байгаа эсэх, үр дүн, ямар төрлийн нэвтрүүлгийг хүлээн авах хэрэгцээ шаардлага байгаа талаар тэдний төлөөллөөс авсан судалгааны нэгдсэн мэдээлэл;
- Цаашид дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн талаар зохицуулалтын ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар.

¹ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан.


ТЕЛЕВИЗҮҮД ХАДМАЛ ТАЙЛБАР, ДОХИОНЫ ХЭЛТЭЙ НЭВТРҮҮЛЭГ БЭЛТГЭН НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

(2023 оны телевизүүдийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүнгээс)

Өнөөдрийн байдлаар тусгай зөвшөөрлөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, орон нутгийн 3 телевиз болон цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлэгтэй арилжааны 26 телевиз гэсэн нийт 47 телевизэд тодорхой тооны нэвтрүүлгээ дохионы хэлтэй эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэх үүрэг хүлээлгэдэг.

Тэгвэл 2023 оны байдлаар нийт 53 телевизээр 9445 цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол үүний 67.82% буюу 27 телевизээр мэдээ, мэдээлэл, 7% буюу 18 телевизээр танин мэдэхүйн нэвтрүүлэг, харин 1% буюу 7 телевизээр хүүхдийн нэвтрүүлгийг тус тус дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. Энэ нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 7508 цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэнтэй харьцуулахад 1937 цагаар өссөн байна. Түүнчлэн 2023 оны байдлаар нийт 46 телевиз 1655 цаг 13 минутын хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна.

Телевизээр нэвтрүүлсэн дохионы хэлтэй нэвтрүүлгийн төрөл (2023 онд 53 телевиз)



2023 онд нийт 53 телевизээр дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн төрөл, жанр, нэвтрүүлсэн цаг, үүнд эзлэх хувь зэргийг Хүснэгт 1²-д үзүүлээ.

Дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн төрөл жанр, цаг (2023 он 53 телевиз)


Хүснэгт 1

Нэвтрүүлгийн төрөл жанр	Мэдээ	Нийгэм, улс төр	Урлаг, спорт	Суртал-чилгаа	Танин мэдэхүй	Хүүхэд	Цэнгээнт	Кино
Нийт дохионы хэлтэй нэвтрүүлэгт эзлэх /цаг:мин:сек, хувь/	67.8%	22.1%	0.3%	0.2%	7.1%	0.8%	1.1%	0.6%
	6406:13:59	2091:19:49	30:48:32	16:28:34	667:32:14	76:15:44	103:23:03	53:29:33

² Дэлгэрэнгүй тайлантай тус Хорооны вэб сайтаас энэхүү <https://shorturl.at/muCS7> линкээр нэвтрэн танилцах боломжтой.

Нийт бичгэн тайлбартай нэвтрүүлэгт эзлэх /цаг:мин:сек, хувь/	2.3%	43.8%	0.1%	0.04%	42.4%	6.8%	1.1%	3.3%
	38:46:29	726:00:00	2:14:49	0:40:34	701:08:47	112:32:16	19:01:37	54:48:25
Нийт цаг	5770:17:12	2380:36:35	32:50:45	17:04:17	1244:58:34	170:32:18	85:53:59	44:02:29

**2023 онд дохионы хэлтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн төрөл,
(нийт дохионы хэлтэй нэвтрүүлэгт эзлэх хувиар)**



Дээрх хүснэгтээс харахад дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн 90 орчим хувь нь мэдээ, мэдээллийн болон нийгэм, улс төрийн нэвтрүүлэг эзэлж байгаа нь бага биш үзүүлэлт гэж харагдаж байгаа ч энэ нь зорилгоо биелүүлж байна уу, сонсголын бэрхшээлтэй хүний мэдээ, мэдээлэл авах, танин мэдэх хэрэгцээг хангаж байна уу гэдэгт хариулт өгөх ёстой.

Тус Хорооноос дээрх үүргийн хүрээнд телевизүүдээр нэвтрүүлж буй дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн хүртээмжийн байдалд эхний байдлаар судалгаа хийж, дээрх зохицуулалтын үр дүнг дүгнэн, цаашид авах арга хэмжээгээ тодорхойлох үүднээс холбогдох байгууллагатай хамтран ажиллахаар төлөвлөсөн. Сонсголын бэрхшээлтэй иргэн ямар төрлийн нэвтрүүлэг ямар хэлбэрээр хүлээн авч үзэх хэрэгцээ шаардлагатай байдаг, телевизүүдээр нэвтрүүлж байгаа дохионы хэлмэрчийн чадвар, мөн нэвтрүүлгийг бичгэн тайлбартайгаар нэвтрүүлэх нь хэр үр дүнтэй байгаа талаар судалж үнэлгээ, дүгнэлт өгөх нь зүйтэй гэж үзсэн.

Энэхүү ажлын хүрээнд эхний удаад Монгол дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулж байгаа баг хамт олонтой уулзаж холбогдох мэдээ мэдээллийг авсан. Монгол дохионы хэлний тухай хуулийн төслийг боловсруулахдаа 2023 оны 6 дугаар сард “Сонсголгүй иргэдийн нөхцөл байдлын судалгаа”-г хийсэн байна. Судалгааны нэг хэсэг нь сонсголгүй иргэдийн мэдээллийн хүртээмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохыг зорьжээ.

Судалгаанд Улаанбаатар хот болон 21 аймгаас нийт 162 иргэнийг хамруулсан бөгөөд тэдгээрийн бичиг үсэг болон дохионы хэлний мэдлэгийн түвшин өөр өөр байсан тул судалгааг дохионы хэлний орчуулагчийн тусламжтайгаар авсан байна.

Судалгаанд нийт 162 сонсголгүй иргэн хамрагдсанаас УБ хотоос 71%, аймаг орон нутгаас 29% оролцсон. Үүнээс эрэгтэй 40.7%, эмэгтэй 59.3% байв. Сонсголын бэрхшээлтэй иргэдийн насны бүтцийг авч үзвэл 18-45 насных 95%-ийг эзэлж байна.

Мэдээллийн хүртээмжтэй байдлын хувьд нийт судалгаанд хамрагдагсдын 22% нь хэлж мэдэхгүй байна, 32% нь муу, 40% нь маш муу гэж хариулсан. Тодруулбал, судалгаанд хамрагдагсдын 70 орчим хувь нь мэдээллийн хүртээмж муу байгаа гэсэн нь энэ төрлийн үйлчилгээ үргэлж үгүйлэгддэг болохыг харуулсан байна.

Нийт судалгаанд оролцогчийн 22% нь фейсбүүкээс, 3% нь вэбсайтаас, 27% нь телевизээс, 48% нь найз нөхөд, гэр бүлийн гишүүдээсээ мэдээ мэдээлэл авдаг гэж хариулжээ.

*Эх сурвалж: Сонсголгүй иргэдийн нөхцөл байдлын судалгааны дүнгээс. 2023.06 сар
(Монгол дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгээс)*

ТЕЛЕВИЗҮҮДИЙН БЭЛТГЭН НЭВТРҮҮЛЖ БАЙГАА ДОХИОНЫ ХЭЛ, ХАДМАЛ ТАЙЛБАРТАЙ НЭВТРҮҮЛГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГАА

Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизүүдэд мэдээ, мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэл, бичгэн тайлбартайгаар нэвтрүүлэх үе шаттай төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу нэвтрүүлэх үүрэг хүлээлгэж байгаа нь сонсголын бэрхшээлтэй иргэдэд хэр ойлгомжтой, хүртээмжтэй хүрч байгаа, цаашид дээрх зохицуулалтад анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага холбоодтой уулзаж, сонсголын бэрхшээлтэй иргэдийн төлөөллөөс цахим хэлбэрээр судалгаа, мэдээлэл авлаа. Судалгаа авахад “Тэгш тусгал” ТББ дэмжиж, цахим судалгаа авах ажлыг 2024 оны 3 дугаар сард зохион байгууллаа. Судалгааны дүнг нэгтгэж үзвэл:

Судалгаанд нийт 61 иргэн хамрагдсанаас, 44% нь монгол дохионы хэлний хэлмэрчийн байрладаг цонхны хэмжээг томруулах, 19% нь үг урсгаж хаахыг болиулах, 20% нь өнгө дүрслэлийг нэмэгдүүлэх, 17% нь гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх хүсэлтэй гэж хариулжээ.

Ямар мэдээллийг монгол дохионы хэлээр авахыг хүсч байна вэ гэсэн асуулгад нийт судалгаанд хамрагдагсдын 39.5% нь мэдээ мэдээллийн, 30.2% нь эрүүл мэндийн, 24.1% нь уран сайхны киноны, 22.2% нь боловсролын, 17.3% нь хууль эрх зүйн, 13% нь танин мэдэхүйн, 21% нь соёл урлаг спортын, 10.5% нь хүүхдийн нэвтрүүлгийн, 3.7% нь мэдэхгүй гэсэн бол үлдсэн хувьд нь дээр дурдсанчлан бүх мэдээллийг бүгдийг нь дохионы хэлээр авах, хадмалаар урсган явуулж байх хүсэлттэй байгаагаа хариулж бичсэн байна. Мөн цаг үеийн шуурхай мэдээ, амьдрах ухаан, Монголын түүх соёл зэргийг авах хүсэлтүүд эзэлжээ.


Зохицуулах хорооны зүгээс энэхүү ажлын хүрээнд 2024 оны 3 дугаар сард зохион байгуулсан 9 асуулт бүхий судалгааны асуулгыг текс байдлаар бэлтгэн судалгааг цахим хэлбэрээр авсан тул зарим сонсголын бэрхшээлтэй иргэн асуулгыг бүрэн ойлгоогүй байх, хариулт нь ойлгомжгүй бичсэн байдал харагдаж байсан.

Дараа дараагийн удаа иймэрхүү төрлийн судалгааг авахдаа асуулгаа давхар дохионы хэлмэртэй видео байдлаар бэлтгэх нь судалгаа үр дүнтэй байхад нөлөөлнө гэж үзлээ.

Энэхүү судалгаанд нийт 61 иргэн хариулсан. Хүйсийн хувьд эмэгтэй 60.7% , эрэгтэй 39.3% байна. Насны бүтцийн хувьд 35-44 насных 45.9%, 45-54 насных 21.3%, 18-25 насных 11.5%, 55-аас дээш насных 3.3%-ийг эзэлж байлаа.

Судалгааны асуулгуудад хэрхэн хариулсныг дор нэгтгэн гаргалаа.


1. “Телевизүүдийн дохионы хэлтэй мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг нь таны хэрэгцээг хангаж чадаж байна уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 14.8% нь тийм гэж хариулсан бол үгүй гэж 23% нь, заримдаа л гэж 62.3% нь хариулсан байна. Үүнээс харахад ямартаа ч нийт судалгаанд оролцогчдын 77% хүртэлх нь телевизээс авах мэдээ, мэдээллийн хэрэгцээгээ тодорхой хэмжээнд авч байна гэж үзэж болохоор байна.



2. “Телевизүүдийн дохионы хэлний хэлмэрчийн дэлгэцийн хэмжээ таны хэрэгцээг хангаж чадаж байна уу?” гэсэн асуултад 31.1% нь тийм буюу хангаж чадаж байна гэж хариулсан бол 68.9% нь дэлгэцийн хэмжээ жижигхэн байгаагаас сайн харагддаггүй гэж хариулсан байна. Бас зарим телевизүүд дохионы хэлмэрчийн урдуур үг үсэг, зарлал, мөнгөний ханш зэргийг байрлуулсан байдаг гэж хариулжээ.

3. “Телевизүүдийн хадмал тайлбартай нэвтрүүлгийн үсгийн хэмжээ, хурд танд ойлгомжтой байж чадаж байна уу?” гэсэн асуултад тийм гэж судалгаанд оролцогсдоос 31 хүн буюу 50.8% нь хариулсан бол үгүй гэж 30 хүн буюу 49.2% нь хариулжээ. Яагаад таны хэрэгцээг хангаж чадахгүй байгаа шалтгаанаа бичнэ үү гэсэн асуултад дараах хариултуудыг өгчээ. Үүнд үсгийн хэмжээ жижиг байдаг тул харагддаггүй, маш хурдан гардаг учир уншиж амждаггүй, цагаан дэвсгэр дээр хар, эсвэл хар дэвсгэр дээр цагаан фонттой байвал харж чадна гэж хариулсан бол сонсголгүй хүмүүс уншиж чаддаггүй байх нь их тул дохионы хэлтэй байсан нь илүү ойлгомжтой байдаг гэжээ. Харин мэргэжлийн хүмүүсийн зүгээс аливаа контентыг бичгэн буюу хадмалтай гаргаснаар сонсголгүй иргэдийн үгийн баялаг сайжирдаг гэж үздэг байна.

4. Телевизийн нэвтрүүлэн дохионы хэлтэй байх, хадмал тайлбартай байхын аль нь таны хэрэгцээг илүү хангаж чадах/чадаж байна вэ? гэсэн асуултад хоёулаа байвал гэж 72.1% нь хариулсан бол 18% нь дохионы хэлтэй, 9.8% нь хадмал тайлбартай байвал гэж хариулжээ.



Мэдээж сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд дохионы хэлмэрч, хадмал тайлбар хоёул байх нь илүү давуу талтай байх нь ойлгомжтой. Харин хадмал тайлбартай нэвтрүүлгээс илүү дохионы хэлтэй байх нь илүү ойлгомжтой байдаг гэж хариулсан байна. Мэдээ, мэдээллийн хөтөлбөр дохионы хэлтэй нэвтрүүлээд харин бусад төрлийн уран сайхны, танин мэдэхүйн зэрэг бүтээл нь хадмал тайлбартай байх нь илүү тохиромжтой байж болох талтай гэж харагдаж байна.

5. Аль телевиз хамгийн сайн дохионы хэлмэрчийн мэдээ, нэвтрүүлэгтэй вэ? Тухайн телевизийн нэрийг бичнэ үү гэсэн асуултад дийлэнх нь C1, TenGer, MNB телевизүүдийн дохионы хэлмэрчид хамгийн сайн нь гэж хариулжээ. Мөн телевизийн дохионы хэлмэрчид танд мэдээллээ бүрэн тодорхой дохиж өгч чадаж байна уу? гэсэн асуултад нэр цохож сайн, тааруу зэрэг хариулт өгчээ.

6. Телевизээр ямар төрлийн контент дохионы хэлтэй, хадмал тайлбартай үзэх хүсэлтэй байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын дийлэх нь шоу нэвтрүүлэг, уран сайхны болон олон ангит кино зэргийг үзэх боломж олгохыг хүссэн байна. Бүхий л төрлийн контентыг дохионы хэл, хадмал тайлбартай хүргэх хүсэлтэй байна гэж 15 нь хариулжээ. Түүнчлэн нэг судалгаанд оролцогч үндэсний хит уран сайхны киног хадмал тайлбартай үзэх хүсэлтэй байгаагаа бичиж ирүүлжээ.



Дүгнэлт

Энэхүү тоон судалгаанаас харахад тус Хорооноос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ тодорхой хэмжээнд үр дүнгээ өгч байна гэж үзэж болох ч зайлшгүй анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудал байна.

Нэгдүгээрт, дохионы хэлмэрчийн цонхны хэмжээг боломжит хэмжээгээр томруулах шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Телевизүүд нэгэнт хөрөнгө хүч гарган дохионы хэлмэрч ажиллуулж байгаа бол түүнийгээ хүртээмжтэй болгоход анхаарч хэмжээг нь томруулах, хэлмэрчийн хөдөлгөөнийг ямар нэгэн зураг, лого, текст зэргээр халхлахгүй байх, цаашлаад хэлмэрчийн арын фон, хувцасны өнгө зэргийг ч бодолцож бэлтгэн нэвтрүүлдэг байх шаардлагатай. Дохионы хэлмэрчийн хэмжээг сонсголын бэрхшээлтэй иргэний хэрэгцээ шаардлагад нийцсэн хэмжээнд хүргэхийн тулд Зохицуулах хорооны зүгээс цаашид дохионы хэлний хэлмэрчийн хэмжээг заасан стандарттай байх талаар холбогдох судалгааг хийх, шаардлагатай стандартыг боловсруулах, түүнчлэн телевизүүд үндсэн нэвтрүүлэг дохионы хэлтэй видео дүрсийн сигналыг тус тусад нь дамжуулах, тусдаа ирсэн сигналуудыг IPTV үйлчилгээ эрхлэгч холбогдох боловсруулалт хийж дамжуулснаар хэрэглэгч дохионы хэлмэрчийн дүрсийг телевизийн удирдлагаараа томруулж жижгэрүүлэх боломж, өнөөгийн нөхцөл байдлыг тус тус судлах шаардлага гарч байна.

Хоёрдугаарт, телевиз нь аливаа контентоо хадмал тайлбартай нэвтрүүлж байгаа нөхцөлд үсгийн өнгө, дэвсгэр өнгө зэргийг ялгарахуйц байлгах, үсгийн хэмжээг боломжит хэмжээнд хүртэл томруулах зэргээр хүртээмжийг нэмэгдүүлэх;

Гуравдугаарт, сонсголын бэрхшээлтэй иргэд нь телевизээр зөвхөн мэдээ, мэдээлэл авахаас гадна өөрсдийгөө хөгжүүлэх олон талын контент, хууль эрх зүй, боловсрол, эрүүл мэнд, үндэсний түүх, соёлын мэдлэгээ нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд шууд үүрэг болгох боломжгүй хэдий ч сонсголын бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх нэг хэлбэр нь монгол киног хадмал тайлбартай хувилбараар бүтээдэг байх, үүнийг АйПи ТиВи-д сонгон үзэх боломжтой байдлаар байршуулах зэрэг олон улсад нэгэнт хийж хэвшсэн сайн жишгийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Цаашдаа телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд үүрэг болгож байгаа дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн нэр төрөл, жанрыг нэмэгдүүлэхэд мэргэжлийн холбоотой хамтран ажиллах байдлаар үр дүнд хүрэх боломжтой юм.

Хүн бүрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн форматаар мэдээллийг тэгш хүртээмжтэй хүргэх нь бэрхшээлгүй хөгжих боломжийг олгодог.

--oOo--